

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
О.НАРАНДЭЛГЭР ТАНАА:

“ИЛТГЭХ ХУУДАС”

**”Арилжааны журам”-ын хэрэгжилтэд  
хяналт, мониторинг хийсэн тухай**

2022.12.19

Дугаар.06

Улаанбаатар хот

**НЭГ. ХЯНАЛТ, МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ**

**1.1. Хяналт, мониторингийн зорилго:**

Хяналт, мониторингын зорилго нь “Арилжааны журам”-ын хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх, “Арилжаа, зах зээл хөгжүүлэлтийн хэлтэс”-т дотоод хяналт, шалгалт хийж, журмын хэрэгжилтэд хяналт тавих, хэрхэн үр ашигтайгаар хэрэгжүүлж, ямар үр нөлөөтэй ажилласанд дүгнэлт өгөх, илэрсэн алдаа дутагдлын шалтгаан нөхцлийг тогтоож, цаашид авах арга хэмжээний талаар дүгнэлт гаргаж, зөвлөмж өгч, холбогдох албан тушаалтнаар шийдвэрлүүлэхэд чиглэгдэнэ.

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хууль, Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны А/33 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Арилжааны журам”, 2022 оны компанийн хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөө зэргийг тус тус үндэслэн төлөвлөгөөт, дотоод хяналт, мониторингийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

**1.2. Хяналт, мониторингийн хамрах хүрээ**

1.2.1. Биржийн арилжаанд оролцогч, тэдгээрийн эрх, үүрэг;

1.2.2. Арилжаа зохион байгуулах этгээд;

1.2.3. Арилжааны хэлбэр, арилжааны үе;

1.2.4. Гэрээ, гэрээний үнэ тооцох;

1.2.5. Захиалгын бүртгэл, төрөл, эрэмбэ;

1.2.6. Арилжааны мэдээ

1.2.7 Арилжаанд оролцогчийн хариуцлага;

**1.3. Хяналт, мониторинг хийсэн бүрэлдэхүүн:**

Захиргаа, санхүүгийн хэлтсийн хяналт, мониторингын ахлах мэргэжилтэн  
О.Сайнжаргал

**1.4. Хяналт, мониторингод хамрагдсан хэлтэс:**

Арилжаа, зах зээл хөгжүүлэлтийн хэлтэс

**1.5. Хяналт мониторингд хамрагдсан хугацаа:**

2022 оны 1 дүгээр сараас 2022 оны 12 дүгээр сар хүртэл

**1.6. Хяналт, мониторинг хийсэн хугацаа:**

2022 оны 11 дүгээр сарын 28-нээс 2022 оны 12 дүгээр сарын 16-н хүртэл

“Арилжааны журам”-ын хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх ажлын хүрээнд “Арилжаа, зах зээл хөгжүүлэлтийн хэлтэс”-ийн арилжаа зохион байгуулагч, арилжаа хянагч болон арилжаанд оролцогчтой биечлэн уулзаж, журмын хэрэгжилтийн талаар асуулга явуулж, биржийн арилжааны цахим системийн дата өгөгдлийн баримтыг нэг бүрчилэн шалгаж, дүгнэлт гаргав.

## **ХОЁР. ХЯНАЛТ, МОНИТОРИНГИЙН ҮР ДҮН**

Дотоод хяналт, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэхдээ 2021 оны 1 дүгээр сарын 01-ээс 2022 оны 12 дүгээр сарыг дуустал хугацааг хамааруулан хийж гүйцэтгэлээ.

### **2.1. Биржийн арилжаанд оролцогч, тэдгээрийн эрх, үүрэг;**

Арилжаа, зах зээл хөгжүүлэлтийн хэлтэс нь “Арилжааны журам”-ийн 3.2.1, 3.2.2, 3.2.3, 3.2.4 заалтын дагуу байнгын болон байнгын бус гишүүдийн биржийн арилжааны системд авах, зарах захиалга оруулах, өөрчлөх, цуцлах, захиалгын жагсаалтыг биржийн системээр дамжуулан авах, Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн хуулийн дагуу биржээр арилжсан бараа түүхий эдийн тодорхойлолт авах зэрэг эрхүүдийг хангаж, ажилласан байна.

Биржийн арилжаанд оролцогчид нь журмийн 3.3.1, 3.3.2, 3.3.3, 3.3.4, 3.3.5 заалтын дагуу биржийн холбогдох дүрэм, журмыг дагаж мөрдөх, арилжааны үед биржийн системд зөвшөөрөгдсөн үйлдлийг хийх, цахим арилжаанд оролцох тоног төхөөрөмж, сүлжээний бэлэн байдлыг өөрийн зүгээс хангах, биржийн системд нэвтрэх нэр болон нууц үгийг бусдад шилжүүлэхгүй байх зэрэг үүргүүдийг хангаж, ажилласан байна.

### **2.2. Арилжаа зохион байгуулах этгээд;**

Арилжаа зохион байгуулагч нь “Арилжааны журам”-ийн 4.2.1, 4.2.2, 4.2.3, 4.2.4 заалтын дагуу биржийн арилжааг ил тод шударгаар явуулах, хараат бус байх, арилжааны бэлтгэл ажлыг хангах, арилжааг нээх, хаах, цуцлах, арилжааны явцад программ хангамжийн болон бусад аливаа саатал гарвал холбогдох этгээдэд яаралтай мэдэгдэж арга хэмжээ авах, цагийн хуваарийн дагуу арилжаа эхлэх дуусах мөчийг оролцогчдод мэдэгдэх үүргийг биелүүлж ажилласан байна.

“Цахим хөгжүүлэлт, арилжааны хяналтын хэлтэс”-ийн арилжаа, агуулахын хяналт хариуцсан мэргэжилтэн нь “Арилжааны журам”-ийн 4.1.1, 4.1.2, 4.1.3 заалтын дагуу “Хяналтын журам”-д заасан эрх, үүргийн хүрээнд арилжаанд хяналт тавих, арилжаанд оролцогч нь холбогдох дүрэм, журмыг зөрчсөн нь тогтоогдвол өөрийн эрх мэдлийн хүрээнд зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, арилжааны явцад техникийн болон программ хангамжийн аливаа саатал гарвал энэ тухай саатал эхэлсэн болон дууссан цаг минутаар тэмдэглэл хөтлөх, мэдээлэх үүргийг биелүүлж ажилласан байна.

### **2.3. Арилжааны хэлбэр, арилжааны үе;**

“Арилжааны журам”-ийн 5.3.1, 5.3.2, 5.3.3 заалтын дагуу арилжаа зохион байгуулагч нь а. Арилжааны бэлтгэл үед арилжаа зохион байгуулагч нь биржийн системийн бэлэн байдлыг шалгаж, захиалгыг бүртгэх, өмнөх өдрийн захиалгыг өөрчлөх, цуцлах б. Арилжааны үед үнэ тогтоох, в. Арилжааны хаалтын үед нөхцөлт болон кросс захиалгуудыг биелүүлэх үүргүүдийг хангаж ажилласан байна.

## **2.4. Гэрээ,гэрээний үнэ тооцох;**

“Арилжааны журам”-ийн 5.4.1 заалтын дагуу биржээр арилжиж буй гэрээний үнийг тооцохдоо гэрээний тодорхойлолтод заасан “дуудлага худалдаа”-ны аргыг ашигласан байна.

“Арилжааны журам”-ийн 5.4.2, 5.4.3, 5.4.4, 5.4.5 заалтын дагуу а. Үргэлжилсэн дуудлага худалдаа, б. Англи дуудлага худалдаа, в. Нэг бараан дахь хоёр дахь үнийн дуудлага худалдаа, г. Олон багц бараан дахь хоёр дахь үнийн дуудлага худалдааны аргуудыг ашиглаж эхлээгүй байна. Арилжааны программ хангамжийн хувьд дээрх аргуудыг ашиглах бүрэн боломжтой байна.

“Арилжааны журам”-ийн 5.5.1, 5.5.2 заалтын дагуу биржийн арилжааны үед тогтох үнийн хязгаарлалтыг хэрэгжүүлэх зорилгоор зэрэгцээ зах зээлийн үнэ,гадаад зах зээлийн үнэ,валютын ханшны өөрчлөлт,сүүлийн 20 арилжааны арифметик дундаж,өмнөх өдрийн биржийн жишиг үнэ зэргийг ашиглан EWMA аргачлалаар биржийн тухайн өдрийн жишиг үнийг тодорхойлсон байна.

## **2.5. Захиалгын бүртгэл, төрөл, эрэмбэ;**

“Арилжааны журам”-ийн 6.1.1, 6.1.2, 6.1.3 заалтын дагуу зах зээлийн захиалга, кросс захиалга, нөхцөлт захиалгыг арилжаанд оролцогчид биржийн системд оруулах боломжтой байна.

“Арилжааны журам”-ийн 6.2, 6.3.1, 6.3.2 заалтын дагуу арилжаанд оролцогчийн оруулсан захиалга, арилжааны системд бүртгэгдсэн хугацааны эрэмбээр дугаарлагдан,захиалгын бүртгэлийн санд хадгалагдах бөгөөд үнэ болон цаг хугацааны эрэмбээр захиалга биелэгдсэн байна.

“Арилжааны журам”-ийн 6.4, 6.5 заалтын дагуу арилжаанд оролцогч нь хэсэгчилэн биелэх захиалгын доод хэмжээг заах,үлдсэн захиалгыг цуцлах, тухай агшинд хүчинтэй, арилжааны үед хүчинтэй, цуцлах хүртэл хүчинтэй гэх мэт нэмэлт нөхцөлтэй захиалгууд өгч болох бөгөөд бирж нь арилжааны программ, хангамжийн хувьд дээрх захиалгуудыг биелүүлэх боломжтой боловч арилжаанд оролцогчид ийм төрлийн захиалгуудыг хараахан өгч эхлээгүй байна.

## **2.6. Арилжааны мэдээ**

“Арилжааны журам”-ийн 7.1, 7.2 заалтын дагуу гэрээний нэр, үнэ, хэмжээг тусгасан биржийн арилжааны мэдээг 7 хоног, сар, улирал, жилээр, биржийн арилжааны үнийн индексийг холбогдох журам, тушаалын дагуу тогтоосон аргачлалаар, арилжааны өдөр бүр тооцож олон нийтэд мэдээлсэн байна.

“Арилжааны журам”-ийн 7.4 заалтын дагуу арилжааны мэдээг төрлөөс нь хамааран биржийн албан ёсны цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим шуудан, хэвлэмэл хэлбэрээр мэдээлсэн байна.

## **2.7. Арилжаанд оролцогчийн хариуцлага;**

“Арилжааны журам”-ийн 8.1.1, 8.1.2, 8.1.3, 8.1.4 заалтын дагуу арилжаанд оролцогчид нь харилцагчийн захиалгын цаг хугацааны дараалалд өөрчлөлт оруулах,захиалгыг маягтын дагуу зөв бүртгүүлээгүй,биржийн үнэд санаатайгаар дангаар болон бусадтай үгсэн хуйвалдах замаар нөлөөлөхийг оролдох /манипуляци/,бусад оролцогчийг төөрөлдүүлэх, худал мэдээлэл тараах, арилжааны хэвийн үйл ажиллагаанд саад учруулах зэрэг зөрчил гаргасан арилжаанд оролцогчидод холбогдох журмын дагуу хариуцлага хүлээлгэхээр заасан бөгөөд өнөөдрийг хүртэлх хугацаанд ийм төрлийн ноцтой зөрчил гараагүй байна.

### **Хяналт мониторингийн зөвлөмж:**

“Арилжаа, зах зээл хөгжүүлэлтийн хэлтэс”-ийн үндсэн үүргийн нэг болох биржийн арилжааг ил тод, шударгаар явуулахын тулд бусад хэлтсүүдтэй нягт хамтран ажиллаж, үндэсний үйлдвэрүүд /худалдан авагч/ малчин хоршоо /худалдагч/ хоорондын биржийн арилжааг түлхүү зохион байгуулах шаардлагатай байна.

Үүний үр дүнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой болно:

1. “Арилжааны журам”-ийн 5.4.2, 5.4.3, 5.4.4, 5.4.5 заалтын дагуу а. Үргэлжилсэн дуудлага худалдаа, б. Англи дуудлага худалдаа, в. Нэг бараан дахь хоёр дахь үнийн дуудлага худалдаа, г. Олон багц бараан дахь хоёр дахь үнийн дуудлага худалдааны аргуудыг ашиглах;
2. “Арилжааны журам”-ийн 6.4, 6.5 заалтын дагуу арилжаанд оролцогч нь хэсэгчилэн биелэх захиалгын доод хэмжээг заах, үлдсэн захиалгыг цуцлах, тухай агшинд хүчинтэй, арилжааны үед хүчинтэй, цуцлах хүртэл хүчинтэй гэх мэт нэмэлт нөхцөлтэй захиалгууд өгөх;

Хяналт, мониторингийн зөвлөмжийн хүрээнд хийсэн ажил, үр дүнгийн тайланг 2023 оны 1 дугаар сарын 30-нээс өмнө Захиргаа, санхүүгийн хэлтсийн хяналт, мониторингийн ахлах мэргэжилтэн О.Сайнжаргал-д илгээнэ үү.

Хяналт мониторинг хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн

Хяналт, мониторингын ахлах мэргэжилтэн

О.Сайнжаргал

Танилцсан:

Гүйцэтгэх захирал

О.Нарандэлгэр

Арилжаа, зах зээл хөгжүүлэлтийн

хэлтсийн менежер

Р.Ариунбат